



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 9/25

Дэлгэрхаан сум

Ойн менежментийн төлөвлөгөө
боловсруулахад зарцуулах хөрөнгийг
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.2, 7.4.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын ойн менежментийн төлөвлөгөөг 5 жилээр боловсруулахад зарцуулагдах хөрөнгө гаргасугай.

2.Төлөвлөгөөнд шаардагдах 4,730,250 (дөрвөн сая долоон зуун гучин мянга хоёр зуун тавь) төгрөгийн зардлыг "Аглаг ой" хязгаарлагдмал хувьцаат компаний дансанд шилжүүлсүгэй.

3.Сумын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа төлөв байдлыг нарийвчлан судалж сумын хэмжээнд цаашид 5 жилийн турш ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлд тусгаж төлөвлөх ажлын гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо)-д даалгасугай.

4.Судалгаа шинжилгээний ажил хийхэд хамтран ажиллахыг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат)-д, хяналт тавьж ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (У.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

5. Дээрх ажилд шаардагдах санхүүжилтийн байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас "Аглаг ой" ХХК-ий дансанд шилжүүлэхийг Засагт даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан) нарт даалгасугай.

ДАРГА  Б.ЭНХ-АМГАЛАН

2326910947

